

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАНЫ ГАДААД ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН
ТУХАЙ ТАЙЛАН**

2018 оны 9-р сарын 11

Багануур дүүрэг

1. Албан томилолтын зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/780 дугаар захирамжийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод зохион байгуулагдсан “Монгол-Хятадын хөрөнгө оруулалтын форум”-д “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ийг төлөөлөн оролцож, “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт төсөл”-ийг танилцуулах

2. Зорилгын хэрэгжилт

“Монгол-Хятадын хөрөнгө оруулалтын форум”-ыг ӨМӨЗО-ны Үндэсний шинэтгэлийн хороотой хамтран Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар 2018 оны 09 сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Тус форумд Хятадын талаас 24 аж нэгж байгууллагууд оролцов.

“Монгол-Хятадын хөрөнгө оруулалтын форум”-д ҮХГ-аас

- Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, Бүсчилсэн хөгжлийн бодлого, түүний хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөр,
- Хөгжил ба хөрөнгө оруулалтын бодлого,
- Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслүүдийн танилцуулга тус тус хийгдсэн.

“Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан:

- “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ийн дэлгэрэнгүй танилцуулга
- “Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл”-ийн дэлгэрэнгүй танилцуулга
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төлөвлөгдсөний дагуу концессын хөтөлбөрт оруулах тухай танилцуулга хийж Хөнгөн үйлдвэр байгуулалтын хүрээлэн, Эрчим хүчний судалгаа, зураг төслийн хүрээлэн, Эрчим хүчний компани, ХАА ба Мал аж ахуйн академи, Биотех компани гэсэн 5 аж ахуйн нэгж компаниудтай ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулсан.
- Мөн Хөх хотын Шинжлэх Ухааны Паркийн үйл ажиллагаатай танилцсан.

3. Үр дүн

- Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөгдсөний дагуу гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдэнд төсөл хөтөлбөрөө танилцуулах, хамтран ажиллах гарцыг хайх, эрэлхийлэхэд ихээхэн ач холбогдолтой форум болсон гэж үзэж байна.
- Хятадын талаас Дэд бүтцийн бүтээн байгуулалтанд концессын гэрээнд үндэслэн хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлж байна.
- Энэ арга хэмжээний үеэр Үндэсний хөгжлийн газар нь БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг УХО-ын 2018-2022 оны хөтөлбөрт оруулсан боловч хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр тодорхойгүй байсныг өөрчлөн концессын тендерт оруулах тухай манай саналыг нааштай хүлээн авч хэлэлцэхээр боллоо.

4. Санал дүгнэлт

- БҮТП-ийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай үйл ажиллагааны болон төслийн санхүүжилтийг цаг тухайд нь шийдвэрлэж байх
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн зүгээс Үндэсний Хөрөнгө оруулалтын газарт дараах хүсэлтийг тавих. Үүнд:
 - БҮТП-ийн дэд бүтцийн санхүүжилт, бүтээн байгуулалтыг УХО-ын концессын тендерт оруулж өгөх тухай

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ч.ЭЛБЭГСАЙХАН

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА

